СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/43/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2023 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: М.Нарантуяа<br>Утас: 70518396<br>Аудитын менежер: Г.Даваа<br>Утас: 70512123<br>Аудитор: Ө.Золзаяа<br>Утас: 70512127 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 12
4.1 Ерөнхий зүйл ..... 12
4.2 Материаллаг байдал ..... 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 14
5.1 Төлбөрийн акт ..... 14
5.2 Зөвлөмж ..... **Error! Bookmark not defined.**
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 64

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.СҮХБОЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын ЗДТГ нь төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системд нэвтэрсэн бөгөөд санхүүгийн программ шинэчлэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын ЗДТГ 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 88.7 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **736,817,936.40** | **627,963,548.40** |
| **33** | **АВЛАГА** | **108,044,388.00** | **0.00** |
| **33500** | **Бусад авлага** | **108,044,388.00** | **0.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 41,309,388.00 | 0.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 66,735,000.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **628,773,548.40** | **627,963,548.40** |
| **35400** | **Хангамжийн материал** | **608,773,548.40** | **607,963,548.40** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 810,000.00 | 0.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 885,000.00 | 885,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 607,078,548.40 | 607,078,548.40 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,668,657,212.73** | **1,852,017,962.73** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,668,657,212.73** | **1,852,017,962.73** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,628,071,212.73** | **1,811,431,962.73** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 955,969,072.01 | 955,969,072.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -77,718,757.56 | -77,718,757.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 190,039,750.00 | 190,039,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -134,774,173.39 | -134,774,173.39 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 217,430,010.00 | 224,425,010.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -129,514,830.42 | -129,514,830.42 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 69,889,511.00 | 69,889,511.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -64,232,385.59 | -64,232,385.59 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 884,656,035.00 | 1,061,021,785.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -283,673,018.32 | -283,673,018.32 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **40,586,000.00** | **40,586,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,586,000.00 | 40,586,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,405,475,149.13** | **2,479,981,511.13** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,405,475,149.13** | **2,479,981,511.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,405,475,149.13** | **2,479,981,511.13** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 689,815,330.77 | 689,815,330.77 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 689,815,330.77 | 689,815,330.77 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,367,275,482.00** | **1,441,781,844.00** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 805,801,407.33 | 1,367,275,482.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 561,474,074.67 | 74,506,362.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 348,384,336.36 | 348,384,336.36 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,405,475,149.13** | **2,479,981,511.13** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,487,140,472.50** | **688,860,650.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **887,600,750.00** | **176,365,750.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **887,600,750.00** | **176,365,750.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **66,735,000.00** | **176,365,750.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 66,735,000.00 | 176,365,750.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 800,865,750.00 | 0.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 20,000,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **599,539,722.50** | **512,494,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **94,440,322.50** | **30,077,500.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 27,439,950.00 | 0.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,655,273.50 | 1,997,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 65,345,099.00 | 15,080,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **505,099,400.00** | **482,417,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 505,099,400.00 | 482,417,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **667,124,952.75** | **614,354,288.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **667,124,952.75** | **614,354,288.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **613,760,634.13** | **584,541,907.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **270,757,875.12** | **284,408,329.29** |
| 210101 | Үндсэн цалин | 220,385,939.87 | 182,448,999.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,412,479.80 | 48,077,486.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 12,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,391,310.27 | 10,833,034.15 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,568,145.18 | 30,288,809.24 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,453,445.26** | **38,528,278.25** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,789,948.77 | 25,999,778.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,622,600.00 | 2,570,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,048,700.00 | 5,876,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 559,000.00 | 626,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,433,196.49 | 3,455,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **54,287,384.00** | **44,631,717.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,641,367.00 | 6,841,866.37 |
| 210302 | Түлш, халаалт | 45,836,017.00 | 37,789,851.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 810,000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **29,383,516.00** | **28,853,514.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,894,900.00 | 6,942,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,647,816.00 | 19,338,724.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,680,000.00 | 2,370,390.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 160,800.00 | 201,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,677,500.00** | **12,810,200.00** |
| 210602 | Тавилга | 0.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,677,500.00 | 11,810,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,138,000.00** | **7,620,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,138,000.00 | 7,620,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **48,426,488.00** | **43,025,964.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47,453,230.00 | 42,476,964.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 273,925.00 | 321,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 273,325.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 36,008.00 | 40,684.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 302,000.00 | 99,316.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **166,636,425.75** | **124,663,905.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,627,681.50 | 119,104,871.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 795,000.00 | 5,559,034.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 130,213,744.25 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,364,318.62** | **29,812,380.09** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **25,340,086.00** | **16,420,524.00** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 90,720.00 | 0.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 8,102,680.00 | 8,261,080.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,511,936.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,634,750.00 | 8,159,444.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **28,024,232.62** | **13,391,856.09** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,477,059.62 | 7,047,242.17 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,547,173.00 | 6,344,613.92 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **820,015,519.75** | **74,506,362.00** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **258,541,445.08** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 258,541,445.08 | 0.00 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **561,474,074.67** | **74,506,362.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **600,439,722.50** | **618,544,900.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **600,439,722.50** | **618,544,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **95,340,322.50** | **136,127,500.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 27,439,950.00 | 0.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,655,273.50 | 1,997,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 66,245,099.00 | 121,130,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **505,099,400.00** | **482,417,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 505,099,400.00 | 482,417,400.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **600,439,722.50** | **611,549,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **600,439,722.50** | **611,549,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **507,760,403.88** | **583,425,199.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **271,172,474.12** | **284,408,329.29** |
| 210101 | Үндсэн цалин | 221,203,135.36 | 182,448,999.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,412,479.80 | 48,077,486.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 12,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,391,310.27 | 10,833,034.15 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,165,548.69 | 30,288,809.24 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,624,247.26** | **38,528,278.25** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,960,750.77 | 25,999,778.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,622,600.00 | 2,570,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,048,700.00 | 5,876,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 559,000.00 | 626,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,433,196.49 | 3,455,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **77,251,168.00** | **40,642,941.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,641,367.00 | 6,841,866.37 |
| 210302 | Түлш, халаалт | 68,799,801.00 | 33,801,075.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 810,000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **30,193,516.00** | **28,538,630.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,704,900.00 | 6,957,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,647,816.00 | 18,731,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,680,000.00 | 2,370,390.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 160,800.00 | 478,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,677,500.00** | **12,600,000.00** |
| 210602 | Тавилга | 0.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,677,500.00 | 11,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,138,000.00** | **7,620,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,138,000.00 | 7,620,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **48,426,488.00** | **52,729,050.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 47,453,230.00 | 52,180,050.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 273,925.00 | 321,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 273,325.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 36,008.00 | 40,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 302,000.00 | 100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **37,277,010.50** | **118,357,971.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,482,010.50 | 117,557,971.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 795,000.00 | 800,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **92,679,318.62** | **28,124,700.09** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **25,340,086.00** | **14,732,844.00** |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 8,193,400.00 | 8,193,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 12,511,936.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,634,750.00 | 6,539,444.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **67,339,232.62** | **13,391,856.09** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,477,059.62 | 7,047,242.17 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 44,862,173.00 | 6,344,613.92 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **0.00** | **6,995,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **0.00** | **6,995,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **6,995,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **0.00** | **6,995,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 6,995,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **0.00** | **-6,995,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 689,815,330.77 | 348,384,336.36 | 805,801,407.33 | 1,844,001,074.46 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 689,815,330.77 | 348,384,336.36 | 805,801,407.33 | 1,844,001,074.46 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 561,474,074.67 | 561,474,074.67 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 689,815,330.77 | 348,384,336.36 | 1,367,275,482.00 | 2,405,475,149.13 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 689,815,330.77 | 348,384,336.36 | 1,367,275,482.00 | 2,405,475,149.13 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 689,815,330.77 | 348,384,336.36 | 1,367,275,482.00 | 2,405,475,149.13 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 74,506,362.00 | 74,506,362.00 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 689,815,330.77 | 348,384,336.36 | 1,441,781,844.00 | 2,479,981,511.13 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **515,514,000.00** | **475,370,157.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **515,514,000.00** | **475,370,157.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **499,750,600.00** | **460,874,813.83** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **302,230,800.00** | **281,959,316.29** |
| 210101 | Үндсэн цалин | 197,586,000.00 | 179,999,986.00 |
| 210102 | Нэмэгдэл | 43,952,900.00 | 48,077,486.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,160,000.00 | 12,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 10,454,200.00 | 10,833,034.15 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 35,077,700.00 | 30,288,809.24 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,151,600.00** | **38,021,245.17** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,623,100.00 | 25,492,745.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,570,300.00 | 2,570,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,876,600.00 | 5,876,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 626,500.00 | 626,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,455,100.00 | 3,455,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **38,838,000.00** | **37,951,141.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,300,000.00 | 5,947,532.37 |
| 210302 | Түлш, халаалт | 31,738,000.00 | 32,003,609.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **24,321,200.00** | **24,211,090.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,600,000.00 | 4,600,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,976,400.00 | 16,971,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,476,000.00 | 2,370,390.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 268,800.00 | 268,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **250,000.00** | **0.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 250,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,595,000.00** | **8,595,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,995,000.00 | 6,995,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,536,000.00** | **7,620,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,536,000.00 | 7,620,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **61,136,000.00** | **52,729,050.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 60,000,000.00 | 52,180,050.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 225,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 321,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 276,000.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 95,000.00 | 88,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,000.00 | 40,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 100,000.00 | 100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,692,000.00** | **9,787,971.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,892,000.00 | 8,987,971.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 800,000.00 | 800,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,763,400.00** | **14,495,344.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **15,763,400.00** | **14,495,344.00** |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 8,193,400.00 | 8,193,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,570,000.00 | 6,301,944.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **515,514,000.00** | **475,370,157.83** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **515,514,000.00** | **475,370,157.83** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 515,514,000.00 | 475,370,157.83 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар “Сум орон нутгийн хөгжил дэвшлийг хангаж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэн бүрт ил тод, жигд хүртээмжтэй хүргэх” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,506.3 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| ***Үзүүлэлт*** | ***Эхний үлдэгдэл*** | ***Эцсийн үлдэгдэл*** | ***Өөрчлөлт*** |
|---|---|---|---|
| ***Б*** | 1 | 2 | 3=2-1 |
| ***Мөнгөн хөрөнгө*** | - | - | - |
| ***Авлага*** | 108,044.4 | - | (108,044.4) |
| ***Бараа материал*** | 628,773.5 | 627,963.5 | (810.0) |
| ***Үндсэн хөрөнгө*** | 1,668,657.2 | 1,852,018.0 | 183,360.8 |
| ***Нийт хөрөнгө*** | 2,405,475.1 | 2,479,981.5 | 74,506.4 |
| ***Өр төлбөр*** | - | - | - |
| ***Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/*** | 2,405,475.1 | 2,479,981.5 | 74,506.4 |
| ***Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн*** | 2,405,475.1 | 2,479,981.5 | 74,506.4 |

- *Авлагын данс 108,044.3 мянган төгрөгөөр буурссан нь өмнөх оны авлагын үлдэгдэл барагдсан нь нөлөөлсөн байна.*
- *Үндсэн хөрөнгө данс 1,852,018.0 мянган төгрөг болж 183,360.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 6,995.0 мянга, үнэ төлбөргүй 176,365.7 мянга нийт 183,360.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан нөлөөлсөн байна.*
- *Засгийн газрын хувь оролцоо данс 74,506.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 461,909.9 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс орон төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 515,514.0 мянга төгрөг батлагдсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг орон нутгийн санхүүжилт 515,514.0 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 475,370.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн санхүүжилт 482,762.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 13,391.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд 26,752.0 мянган төгрөгөөр санхүүжилтийг дутуу олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 475,370.1 мянган төгрөг буюу 92 хувьтай зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101-Үндсэн үйл ажиллагаа | 345,605.9 | 327,221.4 | 18,384.5 | 99 |
| 2 | 80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 17,550.8 | 17,358.1 | 192.7 | 98 |
| 3 | 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 68,593.9 | 59,055.3 | 9,538.6 | 100 |
| 4 | 80714- Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт | 8,193.4 | 8,193.4 | - | 100 |
| 5 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 7,570.0 | 6,301.9 | 1,268.1 | 100 |
| 6 | 81102-Орон нутгийн нөөц хөрөнгө | 60,000.0 | 52,180.0 | 7,820.0 | 100 |
| 7 | 81701-байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 8,000.0 | 5,060.0 | 2,940.0 | 100 |
| **НИЙТ** | | **515,514.0** | **475,370.1** | **40,143.9** | **92** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Золзаяа, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 666,855.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13,337.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], 15,2.3[2]-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 36,608.2 мянган, хангамж, бараа материалын зардал 1,654.9 мянган төгрөгөөр тус тус буурч, дотоод албан томилолт 5,482.0 мянган төгрөгөөр өссөн байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд 144 мэдээлэл оруулснаас 6 мэдээг хугацаа хоцроосон байна. Мөн 2022 оны 4-р улирал болон 2022 оны жилийн эцсийн мэдээллийг шилэн дансны цахим сайтад байршуулаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах албан шаардлага хүргүүлсэн.

---

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

[2] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газарт завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3 Албан* шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Төлбөрийн акт | 1 | 1,994.4 | 1 | 1,994.4 | 100 |
| Зөвлөмж | 3 | - | 3 | - | 100 |
| Нийт дүн | **4** | **1,994.4** | **4** | **1,994.4** | **100** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,999.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг цаг тухайд нь үнэн зөв хөтлөх, батламж мэдэгдлийн хүрээнд толилуулж байх зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага

- ЗДНС-аас зарим арга хэмжээний төсөв, зарцуулалт тодорхойгүй 17,475.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг Засаг даргын захирамжийг үндэслэн хийж, ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлээгүй байна.
- Зааврын дагуу үнэн зөв бөглүүлж, хянаж, баталгаажуулаагүй, ЗДТГ-ын даргын тушаал шийдвэргүй анхан шатны баримтаар ажилчдад 1,670.0 мянган төгрөгийн албан томилолтын нөхөн олговор олгосон байна.
- Нохой устгах ажлын гэрээнд заасан мөнгөн дүнгээс 854.0 мянган төгрөгийг хувь хүний дансаар буцаан авч, төсвөөс гадуур зарцуулалт хийсэн.
- Шилэн дансны цахим системд тайлант онд 144 мэдээлэл оруулснаас 6 мэдээг хугацаа хоцроосон байна. Мөн 2022 оны 4-р улирал болон 2022 оны жилийн эцсийн мэдээллийг шилэн дансны цахим сайтад байршуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх/, 4.1.4 /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2.2 дахь /батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Бараа материалыг улирлын нийт дүнгээр орлого авч, зарлагадсан нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын *иж бүрэн байх, тасалбар болголт* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Сангийн сайдын баталсан маягтын дагуу бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг тухайн цаг хугацаанд хөтлөх, батламж мэдэгдлийн хүрээнд толилуулах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

**/мянган төгрөгөөр/**

| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийсэн | 1 | 1,670.0 | | | 1 | 1,670.0 | | | | | | |
| Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцоогүй | 1 | 17,475.7 | | | 1 | 17,475.7 | | | | | | |
| Төсвөөс гадуур зарцуулалт хийсэн | 1 | 854.0 | | | 1 | 854.0 | | | | | | |
| Шилэн дансанд хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| БМ-ыг стандартын дагуу бүртгэж тайлагнаагүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | 5 | 19,999.7 | - | - | 4 | 19,999.7 | 1 | - | | | | |